

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ЖАРГАЛАНТ СУМЫН 4 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/ 05/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2021 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh  
@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим хаяг:  
Tsetsegsuren.A@audit.gov.mn

Гэрэл Хөхийн тэнцвэр аудит ХХК

Аудитор: Д.Хишгээ

Утас: 99964238 Цахим хаяг: Hishgee.Da@yahoo.com

*Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу*

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч

## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	4
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	7
3. Аудитын тайлан .....	7
3.1. Ерөнхий зүйл .....	7
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	7
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	8
3.4. Материаллаг байдал .....	9
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	9
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.9. Аудитын илрүүлэлт.....	12
Залруулсан алдаа .....	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	13
Аудитын зөвлөмж .....	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	13
4. Менежментийн захидал .....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	14

# 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ. ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав бөг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

**ЖАРГАЛАНТ СУМЫН 4 ДҮГЭЭР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ У.ЦЭЦЭНХҮҮ ТАНАА**

2021.02.18 № 2/63  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**  
Жаргалант сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**  
Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.  
Аудитаар Жаргалант сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.  
Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**  
Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.  
Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*Х. БОЛДБААТАР*

Х. БОЛДБААТАР

001020026

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>19 987 245.4</b>	<b>28 372 134.3</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	98 704.5	35 821.4
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	98 704.5	35 821.4
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	19 888 540.9	28 336 312.9
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	-	2 163 600.0
35130	Эм боох материал	-	2 163 600.0
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	19 888 540.9	26 172 712.9
35420	Аж ахуйн материал	35 000.0	106 400.0
35460	Хүнсний материал	2 954 903.0	2 417 425.0
35470	Бусад хангамжийн материал	16 898 637.9	23 641 637.9
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>726 501 621.5</b>	<b>704 997 141.2</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	726 501 621.5	704 997 141.2
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	633 764 871.6	612 374 641.4
39201	Барилга, байгууламж, орон сууц	1 001 870 362.2	1 001 870 362.2
39202	Хуримтлагдсан элэгдэл	(402 586 038.1)	(416 370 610.2)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	43 121 400.0	46 620 400.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(32 265 162.1)	(37 598 122.2)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	68 325 212.9	68 325 212.9
39208	Хуримтлагдсан элэгдэл	(44 700 903.4)	(50 472 601.4)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	92 736 749.9	92 622 499.8
39301	Програм хангамж	594 500.0	594 500.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(251 750.1)	(366 000.2)
39303	Бусад биет бус хөрөнгө	92 394 000.0	92 394 000.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>746 488 866.9</b>	<b>733 362 0725.5</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>746 488 866.9</b>	<b>733 362 025.5</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	746 488 866.9	733 362 025.5
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	162 845 325.0	162 845 325.0
51101	Өмч: - төрийн	162 845 325.0	162 845 325.0
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	391 993 813.7	378 874 222.3
51210	Өмнөх үеийн үр дүн	391 993 813.7	391 993 813.7
51220	Тайлант үеийн үр дүн	-	(13 126 841.3)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	191 649 728.2	191 649 728.2
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>746 488 866.9</b>	<b>733 362 025.5</b>

### 2.2 АУДИТ ХИЙСЭН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>383 196 150.0</b>	<b>447 906 500.0</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8 072 900.0</b>	<b>6 782 000.0</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	8 072 900.0	6 782 000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6 914 900.0	6 782 000.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6 914 900.0	6 782 000.0
120009	Бусад орлого	1 158 000.0	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>375 123 250.0</b>	<b>441 124 500.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	319 640 700.0	387 948 900.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	319 640 700.0	387 948 900.0
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	50 291 100.0	53 175 600.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50 291 100.0	53 175 600.0
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	5 191 450.0	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5 191 450.0	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>401 129 934.8</b>	<b>461 033 341.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>401 129 934.8</b>	<b>461 033 341.3</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	395 938 484.8	436 727 942.7
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	233 474 029.4	303 273 748.9
210101	Үндсэн цалин	145 843 676.4	226 344 518.9
210102	Нэмэгдэл	69 438 478.0	50 689 078.0
210104	Урамшуулал	18 191 875.0	26 240 152.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30 697 963.2	38 233 654.5

210201	Тэтгэврийн даатгал	21 056 646.4	26 271 706.1
210202	Тэтгэмжийн даатгал	2 477 629.0	3 086 422.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 918 103.2	2 448 977.6
210204	Ажилгүйдлийн даатгал	475 112.6	583 544.5
210205	Эрүүл мэндийн даатгал	4 770 471.9	5 843 004.3
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>45 629 466.0</b>	<b>46 211 874.7</b>
210301	Гэрэл, цахилгаан	3 484 746.0	2 431 117.7
210302	Түлш, халаалт	32 833 520.0	29 605 057.0
210303	Цэвэр, бохир ус	9 311 200.0	14 175 700.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1 138 116.0</b>	<b>1 570 459.0</b>
210401	Бичиг хэрэг	377 500.0	327 600.0
210402	Тээвэр, шатахуун	18 682.0	84 800.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	203 000.0	101 000.0
210404	Ном, хэвлэл	-	30 000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	79 000.0	470 780.0
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	459 934.0	556 279.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>54 697 537.8</b>	<b>20 865 625.3</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65 900.0	952 720.0
210502	Хоол, хүнс	53 869 837.8	19 103 905.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	761 800.0	809 000.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4 133 600.0</b>	<b>-</b>
210604	Урсгал засвар	4 133 600.0	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>73 000.0</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	73 000.0	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>747 618.0</b>	<b>529 000.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	315 618.0	97 000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432 000.0	432 000.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>25 347 154.4</b>	<b>26 043 580.3</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	765 000.0	1 040 100.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24 582 154.4	25 003 480.3
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5 191 450.0</b>	<b>24 305 398.7</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5 191 450.0</b>	<b>-</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5 191 450.0	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>24 305 398.7</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	24 305 398.7
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(17 933 784.8)</b>	<b>(13 126 841.3)</b>

### 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>376 281 250.0</b>	<b>441 124 500.0</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1 158 000.0</b>	<b>-</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1 158 000.0</b>	<b>-</b>
120009	Бусад орлого	1 158 000.0	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>375 123 250.0</b>	<b>441 124 500.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>319 640 700.0</b>	<b>387 948 900.0</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	319 640 700.0	387 948 900.0
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>50 291 100.0</b>	<b>53 175 600.0</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50 291 100.0	53 175 600.0
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>5 191 450.0</b>	<b>-</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5 191 450.0	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>375 961 250.0</b>	<b>441 124 500.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>375 961 250.0</b>	<b>441 124 500.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>370 769 800.0</b>	<b>416 819 101.3</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>221 563 660.0</b>	<b>303 321 720.3</b>
210101	Үндсэн цалин	165 535 660.0	202 193 816.2
210102	Нэмэгдэл	41 999 000.0	74 835 017.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2 641 800.0
210104	Урамшуулал	14 029 000.0	23 651 087.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30 000 240.0</b>	<b>38 122 800.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	22 179 640.0	25 962 800.0
210202	Тэтгэмжийн даатгал	1 290 400.0	3 040 000.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 751 600.0	2 428 300.0
210204	Ажилгүйдлийн даатгал	425 100.0	611 700.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4 353 500.0	6 080 000.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>46 096 900.0</b>	<b>49 601 874.7</b>
210301	Гэрэл, цахилгаан	3 520 180.0	2 431 117.7
210302	Түлш, халаалт	33 265 520.0	32 995 057.0

210303	Цэвэр, бохир ус	9 311 200.0	14 175 700.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	926 850.0	669 100.0
210401	Бичиг хэрэг	190 800.0	107 900.0
210402	Тээвэр, шатахуун	61 700.0	143 500.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	102 500.0	101 000.0
210404	Ном, хэвлэл	30 000.0	52 800.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	541 850.0	263 900.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	53 769 850.0	22 667 427.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65 900.0	3 208 900.0
210502	Хоол, хүнс	52 862 500.0	18 566 427.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	841 450.0	892 100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4 667 600.0	556 279.0
210604	Урсгал засвар	4 667 600.0	556 279.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	127 400.0	92 900.0
210702	Дотоод албан томилолт	127 400.0	92 900.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	12 267 300.0	528 000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12 267 300.0	96 000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	432 000.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1 350 000.0	1 259 000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 350 000.0	1 259 000.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5 191 450.0</b>	<b>24 305 398.7</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5 191 450.0	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5 191 450.0	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	24 305 398.7
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	24 305 398.7
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>320 000.0</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>320 000.0</b>	<b>-</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>320 000.0</b>	<b>-</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	320 000.0	-
223001	Бусад хөрөнгө	320 000.0	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(320 000.0)</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		-

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	162 845 325.0	191 649 728.2	409 927 598.4	764 422 651.6
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>162 845 325.0</b>	<b>191 649 728.2</b>	<b>409 927 598.4</b>	<b>764 422 651.6</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	(17 933 784.8)	(17 933 784.8)
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>162 845 325.0</b>	<b>191 649 728.2</b>	<b>391 993 813.7</b>	<b>746 488 866.9</b>
<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>162 845 325.0</b>	<b>191 649 728.2</b>	<b>391 993 813.7</b>	<b>746 488 866.9</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>162 845 325.0</b>	<b>191 649 728.2</b>	<b>391 993 813.7</b>	<b>746 488 866.9</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	(13 119 591.3)	(13 126 841.3)
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>162 845 325.0</b>	<b>191 649 728.2</b>	<b>378 874 222.3</b>	<b>733 362 025.5</b>

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	441124500.0	416819102.0
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	441124500.0	416819102.0
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	441124500.0	416819102.0
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	304000800.0	303878000.0
210101	Үндсэн цалин	190376300.0	190253500.0
210102	Нэмэгдэл	89786200.0	89786200.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2498800.0	2498800.0
210104	Урамшуулал	21339500.0	21339500.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	41040000.0	38122800.0
210201	Тэтгэврийн даатгал	28880000.0	25962800.0

210202	Тэтгэмжийн даатгал	3040000.0	3040000.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2432000.0	2432000.0
210204	Ажилгүйдлийн даатгал	608000.0	608000.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6080000.0	6080000.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>53032200.0</b>	<b>49601874.7</b>
210301	Гэрэл, цахилгаан	3918500.0	2431117.7
210302	Түлш, халаалт	34938000.0	32995057.0
210303	Цэвэр, бохир ус	14175700.0	14175700.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>580000.0</b>	<b>580000.0</b>
210401	Бичиг хэрэг	123000.0	123000.0
210402	Тээвэр, шатахуун	61700.0	61700.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	101000.0	101000.0
210404	Ном, хэвлэл	70300.0	70300.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	224000.0	224000.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>40439100.0</b>	<b>22813527.3</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3208900.0	3208900.0
210502	Хоол, хүнс	36226500.0	18946427.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1003700.0	658200.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>143400.0</b>	<b>0.0</b>
210604	Урсгал засвар	143400.0	0.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>127400.0</b>	<b>92900.0</b>
210702	Дотоод албан томилолт	127400.0	92900.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>575600.0</b>	<b>544000.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143600.0	112000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432000.0	432000.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1186000.0</b>	<b>1186000.0</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1186000.0	1186000.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>441124500.0</b>	<b>416819102.0</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>387948900.0</b>	<b>367217227.2</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	387948900.0	367217227.2
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>53175600.0</b>	<b>49601874.8</b>
132001	Орон нутгийн төсвөөс	53175600.0	49601874.8

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

### 3. АУДИТЫН ТАЙЛАН

#### 3.1. Ерөнхий зүйл

Жаргалант сумын 4 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг шууд захирагч, цэцэрлэгийн эрхлэгч У.Цэцэнхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд норматив зардал/хоол/, и баримтын бүрдүүлэлт, унаа, хоол, түлшний хөнгөлөлтийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25 -наас 2021 оны 02 дугаар сарын 21-ны хооронд Гэрэлт Хөхийн тэнцвэр аудит ХХК-ны Ховд аймаг дахь салбарын захирал аудитор Д.Хишгээ хариуцаж хэрэгжүүлэв.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй:

Тус цэцэрлэг нь хүүхдийн сурах үйлийг дэмжин, хүүхдийн хөгжилд ахиц гаргах, төлөвшүүлэхэд эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн сургалт үйл ажиллагааг чанартай зохион байгуулан, багшийг мэргэжлээрээ тасралтгүй хөгжихөд дэмжлэг үзүүлэн ажиллаж дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Хүний хөгжлийн төв дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн цэцэрлэгийн үйл ажиллагаа, эцэг эх асран хамгаалагч, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.
- Хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг арилган, хүүхдэд эрүүл ахуйн дадлыг олгож хэвшүүлэх, хүүхдийн үнэлгээг үнэн зөв бодитой хийж хамран сургах тойргийн хүүхдийн цэцэрлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх.
- Багш ажилчдын ёс зүйг чанд мөрдөн ажиллах, багш нарыг ажлын байран дээр хөгжих боломжоор хангах, арга зүйг сайжруулах шинэ технологи туршлагыг бусдад түгээн дэлгэрүүлэх.
- Багаараа болон сонирхлын бүлгээрээ нэгдэн цахим үйл ажиллагаа хэрэглэгдэхүүн бэлтгэн туршиж өдөр тутмын үйл ажиллагааг чанартай төлөвлөн зохион байгуулах.
- Хүүхдийг эх хэлээрээ зөв ярих чадварыг сайжруулан ардын уламжлалт тоглоом наадгай, ёс заншлаас суралцуулах.
- “Чадварлаг багш” “Номын гэгээ” “Авьяас хөтөлбөр”-ийн хүрээнд хүүхдийн авьяасыг нээн хөгжүүлэх өөрийгөө илэрхийлэх чадварыг хөгжүүлэх.
- Үзэл баримтлал орчны стандартын дагуу тав тухтай осол аюулгүй эрүүл орчныг бүрдүүлэх.
- Хүүхдийн хоолыг амин дэм шимт тэжээлээр баяжуулах, хоолны цэс төрлийг сайжруулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот “Хоолны зардлын норматив тогтоох тухай”*

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Тус байгууллага санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тайлант онд хяналт шалгалт хийж нийт 3616.7 мянган төгрөгийн акт тавигдсан байна.

Тухайн оны шилэн дансны мэдээллээ хугацаандаа оруулж улирал тутам тайлангаа илгээсэн тул зөрчил илрээгүй байна. Сар бүр Жаргалант сумын төрийн сангийн мэргэжилтэн хяналт тавьж, гүйцэтгэлийг үнэлэхэд 99-100%аар дүгнэгдсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд БАГА гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлого сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 314737,0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3147,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 2 хувиар 8917.3 мянган төгрөгөөр тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13119.6 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	
			Дүн	Хувь
Б	1	2	3=2-1	
Мөнгөн хөрөнгө				
Авлага	98.70	35.80	62.90	63.7%
Урьдчилгаа			-	
Бараа материал	19 888.50	28 329.06	- 8 440.52	-42.5%
Үндсэн хөрөнгө	726 501.60	704 997.10	21 504.50	3.0%
<b>Нийт хөрөнгө</b>	<b>746 488.80</b>	<b>733 362.20</b>	<b>13 126.80</b>	<b>0.24</b>
Өр төлбөр				
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	746 488.80	733 362.20	13 126.80	0.2%
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>746 488.80</b>	<b>733 362.20</b>	<b>13 126.80</b>	<b>0.24%</b>

Авлага дансны үлдэгдэл 35.8 мянган төгрөг болж 62.9 мянган төгрөгөөр буурсан нь татвар ндш-ын тооцооллоос зөрүүгээр гарсан авлага юм. Тус байгууллагуудтай тооцоо нийлж өглөг авлагаа баталгаажуулсан бөгөөд дараа онд бүрэн барагдах боломжтой авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 28336.3 мянган төгрөг болж 8447.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 27164.5 мянган төгрөгийн бараа материалын худалдан авч, 21999.8 мянган төгрөгийн зарлага гаргаж, хандиваар аймгийн ЗДТГ-аас 3283.0 мянган төгрөгийн тоглоом орлого авсан байна.

Эм боох материалын үлдэгдэл 2163.6 мянган төгрөгийн үлдэгдэл нь Жаргалант сумын Засаг даргын 2020-03-20-ны № 1/288 тоот албан бичиг/Жаргалант сумын ЕБС, СӨБ-ыг гамшгаас хамгаалах аюулгүй байдлын нөөцийн жишиг жагсаалт/, 2020-03-13-ны өдрийн Жаргалант сумын онцгой комиссын хурлын шийдвэр № 05 шийдвэрээр эм боох материалын зардал дээр нөөц бэлтгэсэнтэй холбоотой байна.

Хүнсний материалын үлдэгдэл бүртгэлээр 2424.7 мянган төгрөг байгаа бөгөөд складад байхгүй гэрээгээр хүнсний материал бэлтгэн нийлүүлэгч нарт ковид-19-тай холбоотойгоор буцаан олгож, хичээл эхэлсэн үед буцаан авахаар аман тохиролцоо хийсэн байна.

МУ-ын боловсрол шинжлэх ухааны сайдын 2020-11-27-ны А/162 тоот тушаалаар тус цэцэрлэг хоол хүнс тэжээлийн дутагдалд өртөх эрсдэл бүхий өөрийн цэцэрлэгт

хамрагддаг 6 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн орсон 38202 төгрөгийн нэг бүрийн үнэтэй 38202 мянган төгрөгийн үнэ бүхий хоол хүнсийг 1 хүүхдэд олгосон байна.

Хүнсний материал 2424.7, Аж ахуйн материал 106.4, бусад хангамжийн материал БҮТЭЗ 23641.6 мянган төгрөгний үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 704997.1 мянган төгрөг болж 3499.0 мянган төгрөгөөр өссөн БСУГ-аас 2 ш нөөтбүүк хөрөнгө оруулалтаар ирснээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 3499.0 мянган хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны хуримтлагдсан элэгдэл оны эхэнд 479803.8 мянган төгрөг байснаас тайлант онд 25003.5 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгийн дансанд ямар нэгэн өөрчлөлт гараагүй байна. Тус байгууллага өр төлбөр дансны үлдэгдэлгүй. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 733369.3 мянган төгрөг болж /13119.6/ мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

2020-ны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 64710.4 мянган төгрөгөөр буюу 14.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого нь өмнөх оноос тусгай зориулалтын болон орон нутгийн санхүүгийн дэмжлэг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	зөрүү	хувь
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	383 196.15	447 906.50	-64 710.4	- 14.4
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6 914.90	6 782.00	132.9	2.0
Бусад орлого	1 158.00			
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	375 123.25	441 124.50	-66 001.3	- 15.0
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	319 640.70	387 948.90	-68 308.2	- 17.6
Орон нутгийн төсвөөс санхүүжих	50 291.10	53 175.60	-2 884.5	- 5.4
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5 191.45			

Нийт зардал өмнөх оноос 59896.2 мянган төгрөгөөр буюу 12.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 69799.7, нийгмийн даатгалын шимтгэл 7535.7, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд 582.4, хангамжийн материалын зардал 432.3, эд хогшил худалдан авах зардал 4133.6 бараа үйлчилгээний бусад зардал 696.4 мянган төгрөгөөр өсч, нормавит зардал 33839.2 мянган төгрөгөөр буурч, буцаан төвлөрүүлсэн 24305.4 мянган төгрөгний зардлууд байна.

<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>401 129.9</b>	<b>461 026.1</b>	<b>- 59 896.2</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>395 938.5</b>	<b>436 720.7</b>	<b>- 40 782.2</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>233 474.0</b>	<b>303 273.7</b>	<b>- 69 799.7</b>
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30 698.0</b>	<b>38 233.7</b>	<b>- 7 535.7</b>
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>45 629.5</b>	<b>46 211.9</b>	<b>- 582.4</b>
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1 138.1</b>	<b>1 570.5</b>	<b>- 432.3</b>
<b>Нормативт зардал</b>	<b>54 697.5</b>	<b>20 865.4</b>	<b>33 839.2</b>
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4 133.6</b>	<b>-</b>	<b>4 133.6</b>
<b>Томилот, зочны зардал</b>	<b>73.0</b>	<b>-</b>	<b>73.0</b>
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>747.6</b>	<b>529.0</b>	<b>218.6</b>
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>25 347.2</b>	<b>26 043.6</b>	<b>- 696.4</b>
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5 191.5</b>	<b>24 305.4</b>	<b>- 19 113.9</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	24 305.4	- 24 305.4

Энэ нь өмнөх оноос цалин хөлсний зардалд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл шинээр тооцогдон олгогдсон, төсвийн хэмнэлтээс буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан ямар нэгэн өөрчлөлт байхгүй.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 484823.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 484823.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төсөлд 2020 онд хасах тодотгол хийж 43699.2 мянган төгрөгөөр бууруулж 441124.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасан Коронавируст халдвар/ ковид -19/ цар тахалтай холбоотой анх батлагдсан төсвөөс хасаж тодотгол хийсэн 43699.2, оны сүүлчээр зарцуулаагүй үлдэгдэл санхүүгийн дэмжлэгээ буцаан төвлөрүүлсэн 24305.4 бүгд 68004.8 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг зарцуулаагүй байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 441124.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 387948.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын санхүүгийн дэмжлэгээр, 53175.6 мянган төгрөгийг орон нутгийн санхүүгийн дэмжлэгээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 416819.1 мянган төгрөгийн санхүүжилтийн 367217.2 тусгай зориулалтын санхүүгийн дэмжлэг, 49601.9 мянган төгрөг нь орон нутгийн санхүүгийн дэмжлэг авч, нийт 416819.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 416819.1 мянган төгрөгийг зарцуулж 24305.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 416819.1 мянган төгрөг буюу 94.5 хувьтай буюу 24305.4 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Үзүүлэлт	Тайлант оны		
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	441124.5	416819.1	24305.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	304000.8	303878.0	122.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41040.0	38122.8	2917.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53032.2	49601.9	3430.3
Хангамж, бараа материалын зардал	580.0	580.0	0.0
Нормативт зардал	40439.1	22813.5	17625.6
Эд хогшил, урсгал засварын зардал	143.4	0.0	143.4
Томилолт, зочны зардал	127.4	92.9	34.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	575.6	544.0	31.6
Бараа үйлчилгээний бусад зардал	1186.0	1186.0	0.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>441124.5</b>	<b>416819.1</b>	<b>24305.4</b>
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	387948.9	367217.2	20731.7
Орон нутгийн төсвөөс	53175.6	49601.9	3573.7

- Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 122.8 мянган төгрөгөөр хэмнэсэн нь тухайн онд ковид-19 буюу цар тахалтай холбоотой цэцэрлэгийн үйл ажиллагаа хэдэн сараар хүүхэд авахгүй хойшилсон, энэ үед багш, туслах багш нарын илүү цагийн хөлс олгоогүй, жирэмсэн болон хүүхдээ асарч байгаа багшийн оронд түр ажиллаж байсан багшийг амрааж цалинг хэмнэсэн зэргээс шалтгаалжээ.
- Нийгмийн даатгалын шимтгэл: 2917.2 мянган төгрөгөөр хэмнэсэн нь анх төсөв төлөвлөхдөө нэг хувийн илүү тооцооллолт хийгдсэн тул тухайн санд үлдээн буцаан төвлөрүүлсэн байна.
- Байр ашиглалттай холбоотой зардал 3430.3, нормативт /Хоол хүн 17625.6, урсгал засвар 143.4, дотоод томилолт 34.5, бараа үйлчилгээний бусад зардал 31.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь Ковид-19 буюу цар тахалтай холбоотойгоор цэцэрлэгийн үйл ажиллагаа зарим сард ажиллаагүй, зарим сард хагас ажилласан, тайлант онд томилолтоор багш ажилтан яваагүй, зуны улиралд ээлжийн бүлэг ажиллаагүй зэрэгтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээ 24305.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд тус байгууллагын нэмэлт дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2020 онд тухай бүрт нь оруулах 96 мэдээлэл, Сар бүр оруулах 36 мэдээлэл, Улирал тутамд оруулах 4 мэдээлэл, Хагас жилээр оруулах 4 мэдээлэл, Бүтэн жилээр оруулах 11 мэдээлэл нийт 151 мэдээллийг хуулийн хүрээний хугацаанд нь сайт-д оруулан байршуулж ажилласан. Тухай бүр оруулсан мэдээллээс 2, бусад мэдээллээс 1 мэдээлэл хоцорсон байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийн 515.6 мянган төгрөгийн зөвлөмжийг биелүүлэн ажилласан байна.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	515.6	1	515.6			100

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7823.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 7823.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй болно.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар залруулагдаагүй алдаа, зөрчил байхгүй .

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 7823.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

**3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Дараах 2 асуудлыг аймгийн ТЕЗ-ын нэгтгэсэн тайлангийн үеэр анхаарал хандуулж дахин хянаж хэрэгжилтийг нэгтгэн хянах шаардлагатай байна.Үүнд:

- 2020-09-03-ны өдрийн А/483 тоот Ховд аймгийн Засаг даргын захирамжаар Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдийн анги танхим байрны дотоод орчны агаарын чанарыг сайжруулан дэвшилтэт технологи болох “ Окфил”агаар шүүгчийг суулгах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн байна. Тус цэцэрлэгт 30 ширхгийг 6 ангид 3390.0 мянган төгрөгөөр нийлүүлсэн,
- 2020 оны 02 сарын 18-ны Ховд аймгийн Засаг даргын А/107 тоот захирамжаар “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хөрөнгө гаргах тухай захирамжаар Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмнэлтээс 380.0 мянган төгрөгийн маск нийлүүлэх гэрээ хийж Буянт үйлийн шим ХХК-д шилжүүлсэн
- БСУГ-аас хөрөнгө оруулалтаар Dell latitude 3400 CTO Business model 2 ширхэг нөтөбүүкийг нэг бүрийг 1749500 төгрөгөөр 3499,0 төгрөгөөр бэлтгэсэн зэрэг асуудлуудыг аймгийн ТЕЗ-ын нэгтгэсэн тайлангаар авч үзэх шаардлагатай байна.

**4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**Зардлын данстай холбоотой асуудал.****Норматив зардал /Хоол/**

- 1.1. *Илрүүлэлт: Тайлант онд* нийт 8195 хүүхэд өдөрт 19057.7 мянган төгрөгийн хоолонд зарцуулж нэг хүүхдэд 2325.5 төгрөг ноогдож, норматив /2475/ зардлаас 149.5 төгрөгөөр дутуу зарцуулж нийт 1224.9 мянган төгрөгийн хоол дутуу олгосон байна Үнэлгээ, Хэмжилт, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна МУЗГ-ын тогтоол зөрчсөн байна.
- 1.2. *Эрсдэл:хууль , дүрэм , журам зөрчигдөх*  
**Өгсөн зөвлөмж:**

- 1.3. Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот “Хоолны зардлын норматив тогтоох тухай” тогтоолыг мөрдөх
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвшөөрч байна.

**И-баримтын бүрдүүлэлт**

- 2.1 Илрүүлэлт: Тайлант онд шатахууны худалдан авалтыг И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.
- 2.2 Эрсдэл: Төсвийн зарцуулалтын хяналт сулрах, харилцагч байгууллага татвараас зайлсхийх
- 2.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулах
- 2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

**Цалингийн зардал /хоол, унаа, түлшний хөнгөлөлт/**

- 3.1. Илрүүлэлт: Оны эцэст Коронавируст халдвар ковид-19-ын цар тахалтай холбоотой үйл ажиллагаа тасалдсанаас батлагдсан илүү цагийн хөлс хэмнэсэнтэй холбоотой 6598.8 мянган төгрөгийн унаа хоол, түлшний үнийг нэр бүхий 24 албан хаагчдад олгосон байна.
- 3.2. Эрсдэл: төсвийн хөрөнгийг буруу зарцуулах, эдийн засгийн ангилал зөрчих, төсвийн төлөвлөлт буруу төлөвлөх
- 3.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчмыг баримтлан ажиллах
- 3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	Жаргалант сумын 4 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудит код:
2020			ХОА-2021/05/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	Жаргалант сумын 4 дүгээр цэцэрлэг		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	Тайлант онд нийт 8195 хүүхэд өдөрт 19057.7 мянган төгрөгийн хоолонд зарцуулж нэг хүүхэдэд 2325.5 төгрөг ноогдож, норматив /2475/ зардлаас 149.5 төгрөгөөр дутуу зарцуулж нийт 1224.9 мянган төгрөгийн хоол дутуу олгосон байна	1224.9	Зөвлөмж	Захирал	У.Цэцэнхүү
2	Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу	0	Зөвлөмж	Захирал	У.Цэцэнхүү
3	Батлагдсан төсөвт зардал хэмнэсэнтэй холбоотой 6598.8 мянган төгрөгийг унаа хоолны хөнгөлөлтийг нэр бүхий 25 албан хаагчдад олгосон	6598.8	Зөвлөмж	Захирал	У.Цэцэнхүү
<b>ДҮН</b>		<b>7823.7</b>			

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР                      Х.БОЛДБААТАР                      Огноо:2021. 02.17

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР                      А.ЦЭЦЭГСҮРЭН                      Огноо:2021.02.17

БЭЛТГЭСЭН:

ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ ХХК-НЫ ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАРЫН ЗАХИРАЛ, АУДИТОР                      Д.ХИШГЭЭ

Огноо:2021. 02.17